



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 17

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сумын Мал хамгаалах сангийн 1 нэрийн 2,500,000 төгрөгийн эргэлтийн хөрөнгийг тус сангийн данснаас хасахыг зөвшөөрсүгэй.
2. Данснаас хасах хөрөнгийг устгах ажилд хяналт тавьж ажиллахыг сумын Өмч хамгаалах байнгын зөвлөл (С.Отгонбямба)-д даалгасугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ